

МОНГОЛ АРДЫН УРТЫН ДУУ “НАРИЙН САЙХАН ХЭЭР”-ИЙН  
ЭГШИГ ТЭМДЭГЛЭГЭЭНД ХИЙСЭН ШИНЖЛЭЛ

П.Даваапил

**Хураангуй:** Монголын хуучны дуу, аялгууг тэмдэглэсэн дүрс тэмдэглэгээнүүд олноороо олдож байгаа ч тэр нь ямар аялгуу болох, хэрхэн дуулахыг мэдэх, таних хүн ховор болоод байна. Ийм эгзэгтэй цагт Баянхонгор аймгийн орон нутаг судлах музейд хэдэн өвөрмөц баримт хадгалагдаж байна. Өөрөөр хэлбэл “Нарийн сайхан хээр” (урт) “Шивээ хиагт” (богино), “Нэгэн номын дан” (урт), “Нэгэн номын дан” (богино), “Богдын өндөр уул” (урт) зэрэг таван аялгууг Ламын гэгээний хүрээний унзад агсан Л.Юндэнбат дүрст ноотоор тэмдэглэн үлдээсэн байна. Бид энэхүү өгүүлэлдээ Монгол ардын уртын дуу “Нарийн сайхан хээр”-ийн эгшиг тэмдэглэгээг эдүгээ цагийн дуучдын дуулсан хувилбаруудад харгуулан шинжлэл хийхийг зорьж байна.

**Түлхүүр үг:** *Эгшиг тэмдэглэгээ (dbyangs yig), Монгол ардын уртын дуу, Нарийн сайхан хээр, Найруулга, Эгшиг томолт*


**Оршил**

Монгол ардын уртын дуу “Нарийн сайхан хээр”-ийг уртын дуучин Ж.Дорждагва 1970 онд хэвлэсэн “Уртын дуу” номдоо оруулж орчин цагийн ноотод буулгажээ. Мөн Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская нар 1984 онд “Монгол ардын уртын дуу” эмхэтгэлдээ оруулжээ. Энэ хоёр эмхэтгэлд хоёуланд нь уг дууны шүлгийн хэд хэдэн хувилбарыг тэмдэглэсэн байна. 2010 онд доктор Д.Оюунцэцэг “Монголын дуулалт-яруу найргийн төрөл уртын дууны гарал, хувьсал” бүтээлдээ тус дууны аялгууг хөгжмийн хэлбэр зүйн үүднээс нь судалсан байна. 2013 онд доктор С.Соронзонболд “Нарийн сайхан хээр дууны ян-егийг эгшиг тэмдэглэгээтэй харьцуулсны учир” сэдэвт өгүүлэл бичжээ. Эдгээрээс доктор С.Соронзонболдын өгүүллийг эс тооцвол Баянхонгор аймгийн орон нутаг судлах музейд буй уг эгшиг тэмдэглэгээ бараг судлагдаагүй судлагдахуун гэж хэлж болно. Ялангуяа орчин цагт энэ дууг дуулсан дуучдын дуулалттай харьцуулан үзсэн судалгаа байхгүй гэж болно. Тиймээс энэхүү өгүүлэлдээ Ламын гэгээний хийдийн унзад Л.Юндэнбатын тэмдэглэсэн Монгол ардын уртын дуу “Нарийн сайхан хээр”-ийн эгшиг тэмдэглэгээг орчин цагийн дуучдын дуулалттай харьцуулан судаллаа.

**Үндсэн хэсэг**

Доорх зурагт (Зураг 1) муутуу цаасан дээр кирилл үсгээр “Нарийн сайхан хээр” гэж бичээд ард нь дугуй хаалтан дотор төвөд үсгээр “ring” буюу “Урт” хэмээн тэмдэглээд “Нарийн” хэмээх үгийн “Н” үсгээс доош нь таван хар, зургаан улаан цэг тавиад уг дууны эхний хоёр мөрт харгалзах эгшиг тэмдэглэгээг хар болон улаан өнгөөр зэрэгцүүлэн дүрсэлсэн байна. Ингэхдээ уг дууны эгшиг тэмдэглэгээний хоёр талд хоёр давхар улаан

зураас татжээ. Мөн нарийн ажиглавал тус дууны эгшиг тэмдэглэгээний цаана нь дөрвөн параллель шугам татсан байна. Эгшиг тэмдэглэгээний доор нь дууны үгийг кирилл үсгээр хадаж ямар үг, үсгийн үест ямар хэл хоолойн урлал үйлдэхийг зэрэгцүүлэн тэмдэглэсэн байна.



Зураг 1. Нарийн сайхан хээр (урт)


Монгол ардын уртын дуу “Нарийн сайхан хээр”-ийг уртын дуучин Ё.Нямлхагва<sup>1</sup>, Үндэсний урлагийн их театрын уртын дуучин Г.Энхбаатар<sup>2</sup>, уртын дуучин Т.Баянжаргал<sup>3</sup>, Авьяаслаг монголчууд шоуны оролцогч М.Дүгэрсүрэн<sup>4</sup> нарын дуулснаас аялгууг нь баримжаалж болно. Баримжаалж хэмээхийн учир нь өнгөрсөн, одоо, ирээдүй гэх цагийн ялгаагаар, хөгшин залуу гэх насны ялгаагаар, эр эм гэх хүйсийн ялгаагаар, хуурай сэрүүн, чийглэг дулаан гэх уур амьсгал тэргүүтэй олон зүйлийн ялгаагаар дууны аялгуу, дуулах арга дэг, өтгөн шингэн нь өөр өөр байдагт оршино. “Нарийн сайхан хээр” “Урт” гэсний доор таван хар цэг, зургаан улаан цэгийг босоо чигт зэрэгцүүлэн тэмдэглэсэн байна. Үүнийг доктор С.Соронзонболд “Энэ нь үндсэн таван хөг, үүсмэл зургаан хөг гэсэн үг үү, эсвэл ямар нэг чиг баримжааг илтгэх товчилсон утга санаа юу, бүр санамсаргүй зүйл болох эсэхийг алиныг нь яг таг олсон зүйл үгүй” (2013: 210) гэжээ. Ийм цэг “Шивээ хиагт” дуу болон “Нэгэн номын дан” (урт), “Нэгэн номын дан” (богино), “Богдын өндөр уул” (урт)-ын эгшиг тэмдэглэгээнд ч байна. “Шивээ хиагт” дуунд дөрвөн хар цэг байна. Улаан цэг тэмдэглэсэнгүй. “Нэгэн номын дан” (урт)-д арван нэгэн хар цэг, найман улаан цэг байна. “Нэгэн номын дан” (богино)-д таван хар цэг, дөрвөн улаан цэг байна. “Богдын өндөр уул” (урт)-д гурван хар, таван улаан цэг байна. “Богдын өндөр уул” гэх аялгууны гурван хар цэг нь босоо гурван хэрчим гэлтэй доош нь нэлээд урт сунгаж тэмдэглэжээ. Эндээс үзвэл эдгээр хар, улаан цэгнүүд нь санамсаргүй тэмдэглэсэн хэрэг биш бололтой. Чухам ямар учиртайг нь таамаглахад бэрх байна. “Нарийн сайхан хээр” дууны эхний хоёр мөрийг Ж.Дорждагва “Уртын дуу” эмхэтгэлдээ

“Нарийн сайхан хээрийгээ


Аргамжин сойж унаарай хөө” (1970:43) гэж бичсэн байна. Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская нар “Монгол ардын уртын дуу” эмхэтгэлдээ

“Нарийн сайхан хээрийгээ

Аргамжин сойж унаарай” (1984:108) гэж бичжээ. Энэ хоёр мөрд ногдох аялгууг унзад Л. Юндэнбат гурван хэсэг эгшиг тэмдэглэгээгээр тэмдэглэжээ. Эхний хэсэгт нь “Нарийн”, “Сайхан” гэх үгс ногдож байна. Хоёр



дахь хэсэгт



“Хээрийгээ” гэх үг ногдож байна.


<sup>1</sup> <https://soundcloud.com/dooree/lgwsdipplztp>

<sup>2</sup> [https://www.youtube.com/watch?v=Cyydx1Ep\\_wk](https://www.youtube.com/watch?v=Cyydx1Ep_wk)

<sup>3</sup> [https://www.youtube.com/watch?v=L\\_IJ4KUieKE](https://www.youtube.com/watch?v=L_IJ4KUieKE)

<sup>4</sup> <https://www.youtube.com/watch?v=DRySIMrLx1E>

Ингэхдээ “Хээ-рий-гээ” хэмээн гурав салган бичжээ. Гурав дахь хэсэгт “Аргамж”, “Сойгоод” гэх үгс ногджээ.



Ингэхдээ “Сой-гоод” хэмээн хоёр салгаж бичсэн байна. “Сойгоод” хэмээх үгийн араас “Унаарай” гэх үг байх ёстой нь дээрх дөрвөн дуучны дуулалтаас ч тэр, уртын дуучин Ж. Дорждагвын эмхэтгэсэн “Уртын дуу” (1970: 43), Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская нарын эмхэтгэсэн “Монгол ардын уртын дуу” (1984: 108) зэрэг уртын дууны эмхэтгэлээс ч тэр тодорхой байна. Гэтэл энд тэмдэглээгүй байна. Харин “Унаарай” гэх үгэнд харгалзах эгшиг тэмдэглээг тэмдэглэсэн гэж үзэж болохоор байна. Энэ нь дууны аялгуу хэрхэн үргэлжилж, хаашаа хөдөлж, ямар хэл хоолойн урлал хийж буйгаас харагдаж байна. Мөн дууны аялгууг тэмдэглэсэн зурлагын эхэлсэн түвшин, төгссөн түвшин адил байгаа нь үүнийг гэрчилж байна. Түүгээр ч барахгүй Ж.Дорждагва “Нарийн сайхан хээр” дууг “Уртын дуу” номдоо орчин цагийн ноотод буулгасан байна. Энд уг дуу си бемоль (bes)-оос эхлээд мөн л си бемоль (bes) дээр дуусаж байгаа нь үүнийг бататгана (Зураг 2).

**НАРИЙН САЙХАН ХЭЭР**

(Баруун аймгийн аялгуугаар)

*lento - Alluntum*

на-рийн сай-хан хээ-рий-гээ

ар-гам-жин сой-жээ


на-стай бол-сон ээ-жийтэй-гээ нам-рын-хаа сард зол-гоо-рой хөө

эр-эвгэр жо-роо хээ-рийгээ эм-ээллэн сой-ж уна-арай хөө

эм-гэн буу-рал ээ-жтэй-гээ эр-гэж бу-цахдаа зол-гоо-рой хөө

Зураг 2. Ж.Дорждагвын ноотлосон “Нарийн сайхан хээр”

“Нарийн сайхан хээр” уртын дууны эхний хоёр мөрд харгалзах аялгууг дээр өгүүлсэнчлэн гурван хэсэгт хуваасан байна. Доктор Д.Оюунцэцэг “Монголын дуулалт-яруу найргийн төрөл уртын дууны гарал, хувьсал” бүтээлдээ уртын дууны бүтцийг “Эхний хэсэг”, “Дунд хэсэг”, “Төгсгөлийн хэсэг” (2010:108-109) хэмээн хуваасантай таарч байна (Зураг 3). Үүнийг бид уртын дууны амьсгааны завсар, цаашлаад хэмнэлтэй холбоотой болов уу гэж таамаглаж байна.



Зураг 3. Д.Оюунцэцэг уртын дууны хөгжмийн бүтцийг тэмдэглэсэн байдал

Тиймээс дээрх дөрвөн дуучин энэ дууны эхний хоёр мөрийг буюу гурван хэсэгт хуваан тэмдэглэсэн эгшиг тэмдэглэгээ бүхий хэсгийг дуулахдаа хэдэн удаа амьсгаа авч, аль үгийг хэрхэн дуулж буйг ажиглая.

- Ё.Нямлхагва эхний хоёр хэсэг буюу “Нарийн сайхан”, “Хээ-рий-гээ” гэх үгтэй хэсгүүдийг тус бүрд нь нэг амьсгаагаар дуулж байна. Харин сүүлийн “Аргамж”, “Сойгоод” гэх үгтэй хэсгийг дуулахдаа дунд нь гурван удаа амьсгаа авч “Аргамж” гэх үгийг “Аргамжин”, “Сойгоод” хэмээхийг “Сойж” гэж дуулж байна.

- Ё.Нямлхагва эхний хоёр хэсэг буюу “Нарийн сайхан”, “Хээ-рий-гээ” гэх үгтэй хэсгүүдийг тус бүрд нь нэг амьсгаагаар дуулж байна. Харин сүүлийн “Аргамж”, “Сойгоод” гэх үгтэй хэсгийг дуулахдаа дунд нь гурван удаа амьсгаа авч “Аргамж” гэх үгийг “Аргамжин”, “Сойгоод” хэмээхийг “Сойж” гэж дуулж байна.

- Г.Энхбаатар эхний хоёр хэсэг буюу “Нарийн сайхан”, “Хээ-рий-гээ” гэх үгтэй хэсгүүдийг тус бүрд нь нэг амьсгаагаар дуулж байна. Сүүлийн “Аргамж”, “Сойгоод” гэх үгтэй хэсгийг дуулахдаа дунд нь хоёр удаа амьсгаа авч “Аргамж” гэх үгийг “Аргамжлан”, “Сойгоод” хэмээхийг “Сойж” гэж дуулж байна.

- Т.Баянжаргал эхний “Нарийн сайхан” гэх үгтэй хэсгийг нэг амьсгаагаар, “Хээ-рий-гээ” гэх үгтэй хоёр дахь хэсгийг хоёр амьсгаагаар дуулж байна. “Аргамж”, “Сойгоод” гэх үгтэй гурав дахь хэсгийг дуулахдаа дунд нь гурван удаа амьсгаа авч “Аргамж” гэх үгийг “Аргамжлан”, “Сойгоод” хэмээхийг “Сойж” гэж дуулж байна.

- М.Дүгэрсүрэн эхний хэсэг буюу “Нарийн сайхан” гэх үгтэй хэсгийг хоёр амьсгаагаар, “Хээ-рий-гээ” гэх үгтэй хоёр дахь хэсгийг нэг амьсгаагаар дуулж байна. Сүүлийн “Аргамж”, “Сойгоод” гэх үгтэй хэсгийг дуулахдаа дунд нь хоёр удаа амьсгаа авч “Аргамж” гэх үгийг “Аргамжин”, “Сойгоод” хэмээхийг “Сойж” гэж дуулж байна.

- Энэ дөрвөн дуучин дөрвүүлээ “Унаарай хө” хэмээн төгсгөж байна.

**Эндээс дараах ажиглалтуудыг хийж болохоор байна.**

- Ламын гэгээний хүрээний унзад агсан Л.Юндэнбат Монгол ардын дуу “Нарийн сайхан хээр” дууны хоёр дахь мөрийн сүүлийн үг болох “Унаарай” гэх үгийг харгалзах эгшиг тэмдэглэгээний доор нь тэмдэглээгүй үлдээсэн байна.

- “Нарийн сайхан” гэх үгтэй эхний хэсгийг М.Дүгэрсүрэнгээс бусад нь нэг амьсгаагаар дуулж байна.






- “Хээ-рий-гээ” гэх үгтэй хоёр дахь хэсгийг Т.Баянжаргалаас бусад нь нэг амьсгаагаар дуулж байна.

• “Аргамж”, “Сойгоод” гэх үгтэй гурав дахь хэсгийг дуулахдаа Ё.Нямлхагва, Т.Баянжаргал нар тус бүр гурван удаа, Г.Энхбаатар, М.Дүгэрсүрэн нар тус бүр хоёр удаа амьсгаа авч байна.

• Ё.Нямлхагва, М.Дүгэрсүрэн нар “Аргамж” хэмээн тэмдэглэснийг “Аргамжин” гэж дуулж байхад, Г.Энхбаатар, Т.Баянжаргал нар “Аргамжлан” гэж дуулж байна.

• Гурав дахь хэсэгт буй “Сойгоод” гэх үгийг бүгд “Сойж” хэмээн дуулж байна. Ж.Дорждагвын “Уртын дуу” эмхэтгэлд ч Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская нарын “Монгол ардын уртын дуу” эмхэтгэлд ч “Сойж” хэмээн бичсэн байна. Дуучид нь ч бүгд “Сойж” гэж дуулж байна. Тэгэхээр Л.Юндэнбат “Сойгоод” хэмээн буруу тэмдэглэсэн эсвэл тухайн нутагт “Сойгоод” гэж дуулдаг байсан байж болох юм.


• Хэрэвзээ дээрх гурван хэсэг тус бүрийг нэг амьсгаанд дуулах ёстой гэж үзвэл ХХ зууны эхэн үед “Нарийн сайхан хээр” дууг гурван амьсгаанд дуулдаг байсан байж гэлтэй. Тэгвэл дээрх дөрвөн дуучны аль нь ч гурван амьсгаагаар дуулахгүй байна. Нөгөө талаас дээрх дөрвөн дуучин энэ дууны хоёр мөрийг дуулсан хэсэг тус бүрийг нэг бүхэл хэмээн сэтгэж дүрст ноотод буулгавал Ё.Нямлхагвынх 5, Г.Энхбаатарынх 5, Т.Баянжаргалынх 7, М.Дүгэрсүрэнгийнх 6 хэсэг болно.

Зурлагын хувьд татах , нугалах , өргөх , цохих , буулгах -ыг эдгээрийн найруулга байна гэж хэлж болохоор байна. Харин эхний хэсгийн

төгсгөлд байгаа цэг  ямар учиртайг анхааран судлах хэрэгтэй. Ийм цэг “Богдын өндөр

уул” (урт) дууны эхний хоёр хэсгийн ард мөн   тэмдэглэгдсэн байгаа бөгөөд

магадгүй амьсгаа авахыг илэрхийлж байж болох юм. Учир нь Д.Даваасүрэн “Цогт билгэ билгүүн Гомбын зохиолын үргэлжлэл эндүүрэл үгүй адистэдийн эгшгийн тэмдэглэгээ, хөгжмийн тэмдэглэгээ сэлт оршвой” нэрт эгшиг тэмдэглэгээний шастирт “*thig-le nag-po dbugs-yin-par shes*” буюу “хар зураас амьсгаа мөн” хэмээсэн байна гээд “тэдгээр хар зураас бүрийн төгсгөлд дугуй тэмдэг байна (Зураг 4). Уг дугуй дүрсийн утгыг амьсгаа шавхарч байгааг илэрхийлж байна гэж бид үзлээ” (2014:181-182) хэмээсэн байна.



Зураг 4. Амьсгаа тэмдэглэсэн дугуй хар дүрс

Тиймээс энэхүү дугуй хар дүрс нь нэг амьсгаа дуусаад, дахин амьсгаа авахыг тэмдэглэсэн байж болох юм. “Нарийн”, “сайхан” гэх үгтэй эхний хэсэгт буй дугуй хар дүрс М.Дүгэрсүрэнгээс бусдынх нь амьсгаа авч байгаатай таарч байна. Харин бусад газарт яагаад тэмдэглээгүй нь тодорхойгүй байна. Доктор С.Соронзонболд “Дууны шүлгийн бүтэц, хэллэгтэй ян-ег зурлагын хувилбарууд шууд хамааралтай болохыг, Өөрөөр хэлбэл ян-ег зурлагад үгийн хэллэгээс хэмнэл үүсдэгийг” (2013:212) анхааран судлах хэрэгтэй хэмээн



тэмдэглэсэн байна. Энэ нь ч дээрх ажиглалтуудаас тодорхой харагдаж байна. Цаашлаад “Монгол шүлгийн тогтолцооны тодорхойлогч хэмнэлүүд нь мөр бүр ижил хугацаа эзлэх, мөр бүхэн дуудагдах хугацаагаар адил нэгжүүдэд хуваагдах, толгой сүүл холбох, мөрүүд үг зүй, утга санааны хувьд ойртон холбогдох зэргээс бүрддэгийг монгол судлаачид санал нэгтэй тэмдэглэсэн байна. Хэмнэлийн эдгээр үзүүлэлтүүд нь уртын дууны яруу найрагт ч хамаарах боловч дууны хөгжмийн бүтцээс хамааран нэлээд өөрчлөлтөд нэрвэгддэг байна. Тухайлбал, дууны зохиомжийг уртасгахын тулд түүний үгийг урт, богино янз бүрийн хэмжээгээр зориуд аялж үүний улмаас шүлгийн мөрүүд ижил хугацаа эзлэх боломж алддаг юм” (Оюунцэцэг 2010: 107) гэжээ. Тэрхүү хэмнэлийг алдагдуулдаг, өвөрмөц зохиомжийг бүрдүүлдэг зүйл нь уртын дууны эгшиг томолт юм.

Доктор Н.Жанцанноров “Уртын дууны уламжлалт зарим нэр томъёоны гаргалгаа” номдоо “Эгшиг сүлжих гэдэг нь уртын дуу дуулах үндсэн аргын нэг. Үг хэлээд түүнийг орон зайн түвшинд хэлбэр, зохиомж бүрдүүлэх зорилгоор томоохон хэсэг болгон үргэлжлүүлэн аялахад эр, эм эгшгүүдийг зөөлөн гийгүүлэгчтэй заримдаа хавсрах замаар сэлгэдэг. Ха, хэа, хоү, хоө, ээаа, а ха и, ии гэх мэт. Энэ аргыг эгшиг сүлжих гэж нэрлэж байна. Хэдийд, ямар эгшгийн өндөрт, хэр зэрэг хугацаагаар ингэж сүлжих нь уран сайхны чухал боловсруулалт юм” (2005:83) гэжээ. Харин уртын дуучин Б.Батболд “Монгол ардын уртын дууны эгшиг томолт, түүнийг заах арга” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээлдээ “Монгол ардын уртын дууны эхлэл ба төгсгөлийн үг, үгсийн доторх болоод үг хооронд эгшиг сүлжилдэн дуугарч сайхан аялгуу болохыг “эгшиг томох” хэмээн нэрийддэг, ...Монгол ардын уртын дуу нь эхэн ба төгсгөлдөө бас зарим үед дундаа жаа, зээ, лоо, аяа, ая, зээ, хүй, ээ, мину, маань, байду, зээ гэх мэт бас чимэг үгтэй байдаг. Монгол хэлэнд <<а, э, и, о, у, ө, ү>> гэж долоон үндсэн эгшиг авиа байдаг... Энэ эгшгүүдийг уртаар болон ихэвчлэн <<х>> гийгүүлэгчтэй хамсруулж томдог” (2006:31) гэсэн байна. Тэгвэл “Нарийн сайхан хээр” дууны эхний хоёр мөрд ихэвчлэн “и”, “а”, “э” эгшиг болон “х”, “н” гийгүүлэгчийг ашиглан эгшиг томж байна. Энэ нь тухайн мөрөнд орсон үг, түүний авианаас хамаарч байна. Энэхүү эгшиг томолтыг дээрх 4 дуучин тус бүр өөр өөрийн гэх онцлогтой гүйцэтгэж байна.

Мөн “А”, “О”, “У” эр эгшгийг хэлний хойгуур дуудна. Ингэхэд тембрийн хувьд хүнгэнэсэн нам дуу цээжнээс гардаг. “Э”, “Ө”, “Ү” авиаг хэлээ доод үүдэн шүдэндээ хүргэж хэлний үзүүрээр дуудна. Ингэхэд эр эгшгийг бодвол илүү зөөлөн, хаалттай дуу гардаг. “И” эгшиг бол тембрийн хувьд эм эгшигтэй ойролцоо юм” (Оюунцэцэг, 2010:100) гэжээ. Энэ дууны “нарийн”, “сайхан”, “унаарай” гэх мэт үгэнд “а” гэх эр эгшиг “и” гэх саармаг эгшиг оржээ. Ингэхэд энэ үгсийн үед ихэвчлэн хүнгэнэсэн доод өнгө дуурьсаж байна. “хээрийгээ” гэх үгэнд “э”, “и” эгшиг орсон байгаа бөгөөд энэ үгийн үед нарийн дээд өнгө дуурьсаж байна. “Сойж+ээ” гэх үгэнд “о” эгшиг орсон боловч “и” эгшгээр дамжин “ээ” хэмээн томох үед аялгуу доод өнгөнөөс дээшээ шилжиж байна. Тэгэхээр “а”, “о”, “у”-г дуудах үед хүнгэнэсэн нам, “э”, “ө”, “ү”-г дуудах үед уянгалсан нарийн өнгө гардаг байна. Харин “и” эгшиг нь тухайн эр эгшигтэй үгэнд орсон уу, эм эгшигтэй үгэнд орсон уу гэдгээсээ хамааран хүнгэнэсэн нам, уянгалсан нарийн өнгө рүү ижилсдэг бололтой. Мөн энэ эр, эм эгшигтэй үе, үгсийг зөөлрүүлэн холбож өгдөг байна. “А” эгшиг хөгжмийн контекстэд “Э”, “И” юм уу “Ө”, “Ү” эгшгээс дээш байрладаггүй байна. Хөгжмийн фразын түвшинд ч, аягийн түвшинд ч ийм л байдаг. “Ө”, “Ү” нь “О”, “У” эгшгийг бодвол илүү нисэлттэй, чичирсэн хоолой нь чичиргээгүй хоолойноос мөн илүү нисэлттэй байдаг.” (Оюунцэцэг, 2010:101-102) гэсэн нь мөн л тохирч байна. Тэгэхээр цаашид уртын дууны эгшиг томолтыг монгол хэлний авиа зүйтэй холбон гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

### Дүгнэлт

Монголчууд өөрсдийн урт, богино дуугаа дүрс зурлага бүхий эгшиг тэмдэглэгээгээр тэмдэглэх тэмдгийн тогтолцоог хөгжүүлж байжээ. Ингэхдээ хамт төрсөн хөгжим түүний хэл хоолойн урлалууд болох татах, нугалах, өргөх, цохих, буулгах зэрэгт тулгуурлан тэмдэглэдэг байсан байна. Гагцхүү эдгээрийг тэмдэглэхдээ, түүнийгээ үлгэр болгон дуулахдаа дуучин бүрийн, тухайн нутаг бүрийн аялгууны онцлогийг харгалзан үзэж байсан эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл Баянхонгор аймагт дуулагдаж байсан аялгууг гол болгон тэмдэглэсэн үү, эсвэл тодорхой нэг дуучны дуулалтыг гол болгосон уу гэдэг нь тодорхойгүй байна. Ямартай ч үүнд үндэслэн монгол ардын уртын дууны ноот тэмдэглэгээг хөгжүүлэх, дуучдын ялгаатай дуулалт, арга барилуудыг тэмдэглэх боломжтой гэж үзэж болохоор байна.

Эгшиг тэмдэглэгээний төгсгөлд байгаа дугуй хар дүрс нь амьсгаа дуусаж буйг, эсвэл амьсгаа авахыг тэмдэглэсэн бололтой. Гэвч эхний хэсгийн төгсгөлд тэмдэглээд бусад хэсэгт нь тэмдэглээгүй байгааг нягтлан үзэх хэрэгтэй. Үүний сацуу дуучид дуулж буй дууныхаа хаана нь амьсгаа авах уу, үгийнхээ хаана нь таслах уу, үгээ хэрхэн зөв дуудах вэ, аль хэсэгт нь ямар хэл хоолойн урлал оноох вэ гэдгийг сайтар судлах, хянамгай байх хэрэгтэй. Цаашид уртын дуучдын дуулалтын эгшиг тэмдэглэгээнд хөрвүүлэн харьцуулах, тус тусын өвөрмөц онцлог бүхий хэл хоолойн урлалуудыг нь тусгайлан тэмдэглэх, эдгээр дүрс зурлагуудыг орчин цагийн хөгжмийн нооттой хэрхэн хослуулж болохыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

### Summary

There are many image symbols of ancient Mongolian songs and melodies, but few people know what kind of melody they are and how to sing. At such a critical time, the Bayankhongor Aimag Museum of Local Lore has preserved a number of unique documents. In other words, L.Yundenbat, a former Unzad (monk, who starts the congregation recitation) has left an image notes of five melodies such as “Nariin Saikhan Heer” (long), “Shivee Khiagt” (short), “One Book Dan” (long), “One Book Dan” (short), and “Bogd's High Mountain” (long). In this article, we aim to analyze the sound symbols of the Mongolian folk long song “Nariin Saikhan Heer”, by comparative method, based on versions sung by contemporary singers.

### Номзүй

- Батболд Б.** 2006. *Монгол ардын уртын дууны эгшиг томолт, түүнийг заах арга*. Магистрын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.
- Даваасүрэн Д.** 2013. *Эгшиг тэмдэглэгээг түлхүүрдэх боломж ба хэдэн мэдээний утга*. СУИС-ийн Эрдэмтдийн их семинар. Улаанбаатар.
- Дорждагва Ж.** 1970. *Уртын дуу*. Улаанбаатар.
- Оюунцэцэг Д.** 2010. *Монголын дуулалт-яруу найргийн төрөл уртын дууны гарал, хувьсал*. Улаанбаатар. 108-109 х.
- Сампилдэндэв Х., Яцковская К.Н.** 1984. *Монгол ардын уртын дуу*. Улаанбаатар.
- Соронзонболд С.** 2013. *“Нарийн сайхан хээр” дууны ян-егийг эгшиг тэмдэглэгээтэй харьцуулсаны учир*. СУИС-ийн эрдэмтдийн их семинарын илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар. 209-212 х.

### Цахим эх сурвалж

- <https://soundcloud.com/dooree/lgwsdipplztp>  
[https://www.youtube.com/watch?v=Cyydx1Ep\\_wk](https://www.youtube.com/watch?v=Cyydx1Ep_wk)  
[https://www.youtube.com/watch?v=L\\_IJ4KUieKE](https://www.youtube.com/watch?v=L_IJ4KUieKE)  
<https://www.youtube.com/watch?v=DRySIMrLxIE>